

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 34 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 17 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 12 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Хүний Эрхийн Үндэсний комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Зөвлөх үйлчилгээ, худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга- Засгийн газрын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга- Боловсрол, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Хүний эрхийн үндэсний комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалд Баяраагийн Батаад дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Хүний Эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга А.Дашдэлэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны</p>

газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалд Цэдэнбалжирын Минжинхүүд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд Машбатын Угтахбаярт дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан тушаалд Ничибугийн Энхтуяад

		<p>дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цогт-Очирт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн албан хаагчдад дүгнэлт гарган нэр дэвшүүлэх боломжгүй тул буцаахаар шийдвэрлэлээ.</p>
2	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи шуудан, харилцаа холбооны газрын зарим удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга - Хяналт-шинжилгээний газрын Статистик, мэдээллийн хэлтсийн дарга 	<p>Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаагийн 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 1/1375 тоот албан бичгээр тус агентлагийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны 1 дүгээр сарын 16-17-ны өдөр зохион байгуулахаар тогтлоо.</p> <p>Хяналт шинжилгээний газрын Статистик, мэдээллийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд тавигдах шаардлагыг буцаахаар шийдвэрлэв</p>

<p>3</p>	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none"> - Дорнод аймаг - Санхүүгийн зохицуулах хороо - Цаг уур, орчны шинжилгээний газар - Худалдан авах ажиллагааны газар 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 11 дүгээр сарын 18-аас 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 5 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дорнод аймагт 2013 оны 11 дүгээр сарын 18-аас 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 24 иргэнээс 14 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 10 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 6 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 1 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан нэр бүхий 7 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх</p>
----------	---	--

тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Дорнод аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

1. Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн зохицуулах хороо, Цаг уур, орчны шинжилгээний газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 11 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 8 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг

		<p>2 дугаар хавсралтаар батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 8 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Бусад асуудал:</p> <ul style="list-style-type: none"> - УИХ-ын гишүүнээр ажиллаж байсан Д.Ганболдыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай - Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 1996-2000 онд сонгогдон ажиллаж байсан Догсомын Ганболдыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2013 оны 526 тоот албан бичгээр Цагаатгах</p>

		ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга Очир овогтой Лхагварэнцэнд төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн тэргүүн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, О.Лхагварэнцэнд тэргүүн түшмэлийн тэргүүн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ